НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 07 өдөр Дугаар А/27 Улаанбаатар хот

Албан хаагчдын 2022 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэхь хэсэг, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 4.1 дэхь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" А/155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Газрын албан хаагчдын 2022 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний багийн ахлагч:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Содномдэмбэрэл
Гишүүн:	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга В.Батчимэг
Нарийн бичгийн дарга:	Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Д.Оюун-Эрдэнэ

2.Нэгжийн дарга нар албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг хянаж баталгаажуулан тайланг 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор байгууллагын үнэлгээний багт хүлээлгэн өгөхийг даалгасугай.

3.Байгууллагын үнэлгээний баг нэгжийн дарга нарын баталгаажуулсан албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг хянаж 2022 оны 6 дугаар сарын 13-ний дотор дүгнэж, хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулан танилцуулахыг үнэлгээний баг /Х.Содномдэмбэрэл/-т даалгасугай.

ДАРГА Д.БАТСҮХ

1150590201

D:\NAJG 2022\A tushaal tusul\2022.05.30 A27.docx